



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 91

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2.1.7, 5.2.4, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Хулд сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 18,500,000 /арван найман сая таван зуун мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, 3,083,333 /гурван сая наян гурван мянга гурван зуун гучин гурав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй ДУА 0068 улсын дугаартай УАЗ-469 маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 3,000,000 /гурван сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П. Очирбатад үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Хулд сумын Засаг даргын тамгын газрын дарга Н.Баярсайханд даалгасугай.

ДАРГА

С.БУДЖАВ



8100200